

Гамма цацрагийн үйлчлэлээр Усанболор (SiO_2) -т үүсэх парасоронзон дефектийн судалгаа

Н.Төвжаргал^{1,*}, Д.Баатархүү², Т.Очирхуяг¹, Ж.Даваасамбуу¹, and Г.Шилагарди¹

¹Монгол Улсын Их Сургууль, Шинжслэх ухааны сургуулийн

физикийн тэнхим, Улаанбаатар хот 210646, Монгол улс


²Монгол Улсын Их Сургуулийн Цөмийн физикийн судалгааны төв

Янз бүрийн үнэт болон хагас үнэт чулууны өнгийг өөрчилж хүссэн өнгө хэлбэрт оруулах асуудал үргэлж судлаачид төдийгүй хэрэглэгчидийн сонирхлыг татах байдаг. Бид энэ ажлаар байгалийн хагас үнэт чулуу болох усанболор (SiO_2)-ийн өнгийг гамма цацрагийн үйлчлэлээр өөрчилж, түүнд үүсэх парасоронзон дефектийг ЭПР спектроскопийн аргаар судлав. Судалгааны үр дүнгээс үзэхэд дээжийг гамма цацрагаар шарсны үр дүнд түүнд олон тооны парасоронзон төвүүд үүсэнээс усан болорын зоны бүтцэлт өөрчлөлт орж материалын өнгө өөрчлөгдөж байгаагаас гадна дулааны боловсруулалтын горимоос хамааран парасоронzon дефектүүд тодорхой хэмжээгээр өдгөрч байгааг үзүүлэв.

PACS numbers: 61.80.-x, 72.10.Fk, 61.72.Nh

I. ОРШИЛ

Байгалийн үнэт болон хагас үнэт чулуунуудыг гоёл чимэглэл, ахуйн зориулалтаар өргөн хэрэглэдэг. Зарим байгалийн хагас үнэт чулуунуудыг гамма (γ) цацрагаар шарахад тэдгээр нь өнгөний хувиралд ордог γ цацраг хатуу биетэй харилцан үйлчлэхэд тэнд цацрагийн энергиэс хамааран Комптоны сарнил, фотопахилгаан эфект, электрон позитроны хос үүсэх гэх мэт үзэгдлүүд явагдах боломжтой. Эдгээр үзэгдэлүүдийг дагалдан явагдаж байгаа олон процессуудын дунд дээжний өнгө хувирч байгаа болно. Энд үүсэж байгаа өнгөний хувирлын үүсэл шалтгааныг тайлбарлах нь чухал ач холбогдолтой. Түүнчлэн үнэт чулууны өнгийг өөрчлөхдөө ихэвчлэн түүнийг янз бүрийн элемент, бодисоор хольцло замаар янз бүрийн өнгө үзэмж, чанар бүхий материал гаргаж авдаг. Тухайлбал усанболорыг Fe^{+3} ионоор хольцлоход узмэн ягаан өнгөтэй болдог бол Be^{+2} ионоор хольцлоход ногоон өнгөтэй болдог. Болор нь байгаль дээр усанболор, утаат болор, сүүн болор гэж нэрлэгдэх хэлбэрүүдээр элбэг тохиолддог. Эдгээр нь бүтэц найрлагын хувьд ижил боловч кристаллжилтаараа ялгаатай байдаг. Бид энэ ажлаар усанболорт γ -цацрагийн үйлчлэлээр үүсэх эфектийг ЭПР спектроскопийн аргаар дулааны боловсруулалтаас хамааруулан судлах болно. Бид дээжээ сонгоходо байгальд өргөн тархацтай байдаг хагас үнэт чулуу болох усанболор (SiO_2)-ыг сонгож авсан. Энэ чулуу нь гоёл чимэглэлийн зориулалтаар манай орны хувьд өргөн хэрэглэгддэг. Зураг1-т усанболорын кристал бүтцийг үзүүлэв. Энд



Зураг 1: Усанболор (SiO_2) -ийн кристалл бүтэц

кристалл системийн симметр нь $P\bar{3}21(154)$, торын параметрүүд нь $a = b = 4.913\text{\AA}$, $c = 5.405\text{\AA}$, $\alpha = \beta = 90^\circ$, $\gamma = 120^\circ$ болон торын эзэлхүүн $V = 113.03\text{\AA}^3$ болно.


II. УСАН БОЛОРТ ҮҮСЭХ ЦЭГЭН ДЕФЕКТҮҮД

Усанболорыг γ -цацрагаар шарахад түүний өнгө өөрчлөгдөн утаат болор болдог нь цацраг бодисын харилцан үйлчлэлийн дунд кристаллд олон янзын урвал процессууд явагдсаны дунд үүсэх эфектүүдтэй холбоотой. Эдгээр эфектүүдийн нэг нь цэгэн дефект юм [1]. Цэгэн дефектүүд нь үүсгэж байгаа шалтгаанаасаа хамаараад олон янз байх боломжтой. Цэгэн дефектүүд нь эгэл торд атомын шилжилт үүсэх, атомуудын холбоос тасрах болон гадны өөр хольцын атомууд орж ирснээс шалтгаалан атомын бүтцэд гажилт үүсгэдэг [2]. Цэгэн дефектүүдийг тэдгээрийн

*Electronic address: tuvjargal@num.edu.mn

электроны конфигурацид нь үндэслэн хослоогүй электронуудаас тогтож байвал *парасоронзон* дефект, бусад тохиолдуудыг нь *диасоронзон* дефект гэж ангилдаг. Парасоронзон дефект нь хослоогүй электронуудын тэг биш соронзон моментуудаас шалтгаалан соронзон резонансын шингээлт буюу Электроны парасоронзон резонанс (ЭПР) өгдөг.

Цэгэн дефектүүдийн жишээ гэвэл: нүх үүсэх (торын зангилаа цэгт атом алга болох), завсрлын (торын зангилаа биш завсарт атом байрлах) болон валентийн ($\text{Si} - \text{O}$ холбоос эвдрэх) дефектүүд болно. Усанболовт үүсэх цэгэн дефектүүд нь дараахи хэлбэрүүдтэй байна. Үүнд: нейтрал хүчилтөрөгчийн нүх [3]: $\text{O} \equiv \text{Si} - \text{Si} \equiv \text{O}$, перокси гүүрэн: $\text{O} \equiv \text{Si} - \text{O} - \text{O} - \text{Si} \equiv \text{O}$, гүүрэн биш хүчилтөрөгчтэй: $\text{O} \equiv \text{Si} - \text{O}^\bullet$, гурван координаттай цахиуран: $\text{O} \equiv \text{Si}^\bullet$ (ихэвчлэн E' төв гэж нэрлэдэг.), хоёрлосон координаттай цахиуран: $\text{O} = \text{Si}^{\bullet\bullet}$. Эдгээрийн дефектүүдийн дурслэлийг зураг 2-т үзүүлэв. Эдгээр дефектүүд



Зураг 2: Усанболовт (SiO_2)-т үүсэх зарим цэгэн дефектүүд: Энд сумаар электроны спинийг, $-=$, \equiv Si -той холбогдох O -ийн холбоосыг, \bullet -ээр холбоос нь эндээрсэн хослоогүй электроныг, $\bullet\bullet$ -ээр холбоост ороогүй электроны хосыг дурслан үзүүлэв.

нь электрон эсвэл нүхийг барих зарим энергиийн төлвүүдийг үүсгэдгийг тэмдэглэх хэрэгтэй. Цэгэн дефектийн үндсэн болон өдөөгдсөн электроны төлвүүд нь усанболоврын хаалттай бусийн энергиэс бага энергиин завсартай байна. Иймээс $\text{O} \equiv \text{Si} - \text{O}^\bullet$ болон $\text{O} \equiv \text{Si}^\bullet$ дефектүүдийг валентийн болон дамжуулалтын бусийн хооронд байрлах төлвүүдтэй холбоотой үүсдэг тул

эндээрсэн холбоосын төлөв гэж нэрлэдэг. Цахилгаан соронзон орноор үүсгэгдэж байгаа электроны төлвийн шилжилттэй холбоотой дефектүүдтэй холбоотойгоор материалын шингээлтийн болон цацаргалтын бусийн энергийн завсар өөрчлөгдхө бөгөөд энэ нь тухайн материалын тунгалааг чанар өөрчлөгдхө шалтгаан болдог. Мөн эдгээр дефект нь электрон болон нүхийг барих учраас материалын тусгаарлагч чанарыг ч өөрчилдөг. Түүнчлэн парасоронзон дефект нь маш бага ($\sim 10\mu\text{eV}$) засвар бүхий электроны төлвүүдийн дахин хуваарилалт болон соронзон орны нөлөөгөөр материалын соронзон шинж чанар мөн өөрчлөдөг. Парасоронзон дефектүүдээс шалтгаалан материалын оптик шингээлт, цацаргалтын бус өөрчлөгдхө бөгөөд электроны парасоронзон резонансын үзэгдэл ажиглагдах шалтгаан болно. $\text{O} \equiv \text{Si} - \text{O}^\bullet$ болон $\text{O} \equiv \text{Si}^\bullet$ хэлбэрийн дефектүүд нь ^{29}Si болон ^{17}O изотопоор баялаг болсон дээжүүдэд ажиглагдана [4].

γ цацрагийн үйлчлэлээр цэгэн дефект үүсэх процесс

Материалыг халаах, хөргөх болон механик үйлчлэлд оруулах зэрэг янз бүрийн аргаар цэгэн дефектүүд үүсгэж болдог. Үүний нэг болох өндөр энериgi бүхий цацрагийн үйлчлэлээр цэгэн дефект үүсэх механизмыг авч үзье.

Усанболовт цэгэн дефект үүсгэх хамгийн өргөн хэрэглэгддэг механизм нь бөөмсийн (электрон, нейtron, ион гэх мэт) багц цацраг эсвэл иончлогч цацраг (UV, X-ray, γ -цацраг гэх мэт)-аар шарах зэрэг орно. Материалыг γ -цацрагаар шарсаны дунд түүний энериис хамааран олон процесс явагдах боломжтой. Бага энериgi бүхий цацрагийн үйлчлэлээр зонхилон Компьютеры сарнил тохиолдох бөгөөд үүний дунд дараахи хоёр механизм явагддаг. Үүнд:

- Knock-on процесс: энэ нь цацаргалтын кинетик энэргиэ шууд солилцсоны дунд атом шилжих процесс
- Radiolysis процесс: энэ нь электроныг өдөөх эсвэл иончилсонаы дунд атом байрлал шилжих болон холбоос тасрах процесс

Цацрагийн үйлчлэлээр нийт кинетик энэрги хадгалагдах харимхай болон цацаргалтын кинетик энэргийнхээ тодорхой хэсгийг электроны шилжилт хэлбэрээр алдах харимхай биш гэсэн хоёр төрлийн knock-on процессын явагдаг [5]. Атомын шилжилтийн дунд дефект үүсэхийн тулд үйлчилж буй цацраг бай атомын холбоосыг таслахын тулд хангалттай энергитэй байх хэрэгтэй. Атомыг шилжүүлэхэд шаардагдах

энергийг шилжилтийн энерги T_d гэж нэрлэдэг: Энэ нь Si-ийн хувьд $T_d^{Si} \cong 20eV$, O-ийн хувьд $T_d^O \cong 10eV$ байх бол $Si - O$ холбоосын энерги $\sim 5eV$ орчим байдаг [6]. Хурдан нейтрон, дулааны нейтрон, их энергитэй электрон болон γ цацрагаар шарах уед "knock-on" мөргөлдөөний дунд атомын шилжилт үүсдэг. Тухайлбал, усанболовыг хурлан нейтрон ($E > 0.1MeV$)-оор шарах уед атомын шилжилтийн процессийн дунд $\sim 2 \cdot 10^{19}$ спин/см³ парасоронзон төв (нийт хүчилтөрөгчийн атомын 0.05%) үүсдэг байна [7].

Radiolytic процессын уед эхлээд электроны төлвийг өөрчлөх боловч энэ нь тогтвортгүй ион эсвэл атомын дефект хэлбэрээр тогтоно. Эдгээр өдөөгдсөн электронууд нь электроны тогтвортой төлөв хүртэл бусад процессуудын шалтгаан болно. Электроны өдөөлт, иончлол болон холбоос эвдрэх энэ процесс (radiolytic) электрон болон γ цацрагийн үйлчлэлийн уед knock-on процессоосоо хэд дахин их тохиолддог. Цацрагийн үйлчлэлээр үүсэх эффект нь ихэвчлэн материалд шингээгдсэн энергийн хэмжээгээр тодорхойлогддог. Энэ энергийг тодорхойлохын тулд эхлээд сарнилын дифференциал огтлол $\sigma_E(\Theta, T)$ -ийг авч үздэг. Үл хамаарах мөргөлдөөний тохиолдол (knock-on, radiolytic)-уудын хувьд $\sigma_E(\Theta, T)$ нь тусаж байгаа E энериgiи бүхий бөөмсийн T -ээс $T + dT$ энэргийн завсар болон θ -ээс $\theta + d\theta$ хазайлтын өнцгийн завсар дахь магадлалын нягт юм. Дифференциал огтлолоос бай материалын нэгж уртад шилжүүлэх энериgi (- dE/dx)-ийг олох боломжтой. Мөргөлдөөний туршид дээж материалыд шилжих энериgi T бол дээжний dr завсарт шилжүүлэх дундаж энериgi нь:

$$\langle T \rangle = N \delta r \int_0^\pi \int_{T_{\min}}^{T_{\max}} T \sigma_E(\Theta, T) d\theta dT. \quad (1)$$

Энд N нь нэгж эзэлхүүн дэх сарнилын төвийн тоо, T_{\max}, T_{\min} нь шилжүүлэх энэргийн хамгийн их болон бага утга, dr нь нэг мөргөлдөөний хувь дахь хангалттай бага хэмжээс. Түүнчлэн dr завсарт алдсан дундаж энериgi $\langle \Delta E_1 \rangle$ нь дээж материалын нэгж уртад шилжүүлэх энэргитэй тэнцуу:

$$\left(-\frac{dE}{dx} \right) = -\frac{\langle \Delta E_1 \rangle}{\delta r} = N \int_0^\pi \int_{T_{\min}}^{T_{\max}} T \sigma_E(\Theta, T) d\theta dT. \quad (2)$$

Алдсан энэргийг шингээгдсэн дозе гэж нэрлэдэг бөгөөд дээжний зузаан x бол энэ дараахи хэлбэртэй байна.

$$D = \frac{\phi \Delta t}{x} \int_0^x \left| \frac{dE}{dx} \right| dx, \quad (3)$$

энд $\phi \Delta t$ нь тусч байгаа бөөмсийн ургал.

Radiolytic процессын уед үүсдэг түгээмэл дефектүүдийн нэг бол парасоронзон төв юм. Энэ нь хослоогүй электронтой молекулын нэгж бөгөөд түүний шинж чанарыг соронзон орон ашиглан ЭПР спектроскопи ашиглан судладаг [8]. Парасоронзон төвүүд нь photolysis, thermolysis, radiolysis, electrolysis болон бусад химийн урвалын дунд үүсдэг. Хүчилтөрөгч нь парасоронzon төвүүд үүсгэхэд маш идэвхитэй оролцдог. Хамгийн түгээмэл парасоронzon төвүүдэд чөлөөт радикалууд, бираадикалууд, парасоронzon металл ион, гурвалсан үндсэн төлөв бүхий хүчилтөрөгчийн O_2 молекул болон парасоронzon дамжуулалтын төрлүүд орно. Парасоронzon төвүүд нь өөр өөр спин болон тогтвортгилттой байдаг. Парасоронzon төвүүдийн соронzon момент нь тэдгээрийн спинээс хамаарах ба гадны соронzon орны нөлөөгөөр тэдгээр соронzon момент нь цэгцэрсний дунд ЭПР дохио бүртгэгддэг.

Материалд үүсэж байгаа цэгэн дефектүүдийн үүсэх процессыг танин мэдэхийн тулд дулааны боловсруулалтын аргыг өргөн хэрэглэдэг. Цацрагийн үйлчлэлээр үүссэн зарим дефектүүд нь материалын температурыг нэмэгдүүлэхэд алга болдог. Ерөнхийдөө цацрагийн үйлчлэлд орсон материалыг халаахад тодорхой температурт тодорхой дефектүүд арилдаг байна. Түүнчлэн энэ аргаар дефектийн бутэцтэй холбоотой молекулын холбоосын хүч, дефектийн потенциал нүхний гүн зэрэг чухал мэдээлэлүүдийг олох боломжтой. Мөн дулааны боловсруулалтын аргаар тодорхой үзэгдлүүдийн хамаарал зүй тогтолыг судлах боломжтой. Тухайлбал, оптик шингээлтийн спектрокопи болон ЭПР спектроскопи арга ашиглан тодорхой дулааны боловсруулалтын нөхцөл дор материалын макроскопик шинж чанарыг судлах боломжтой. Бид энэ ажлын хүрээнд монгол орны байгалийн дээж болох кристалл усанболов дээжийн хувьд өндөр энериgi бүхий γ цацрагаар шарсан болон шарсны дараа дулааны боловсруулалтанд оруулсан дээжүүдэд үүсэх парасоронzon дефектүүдийн концентрациас нь хамааруулан ЭПР спектроскопийн аргаар судлах зорилготой.

III. ЭЛЕКТРОНЫ ПАРАСОРОНЗОН РЕЗОНАНСЫН ЭФФЕКТ

ЭПР нь соронzon орон дахь дээжинд микродолгионоор илрүүлсэн парасоронzon дефект ажиглагдаг эфект юм [8]. Соронzon орны нөлөөгөөр энэргийн түвшинд Зееманы салалт болдог. Соронzon оронд хослоогүй


электронуудын энергийн түвшинүүд салсны дараа тэдгээрийн соронзон моментууд нь янз бүрийн чиглэлтэй байдаг. Θ.х соронзон индукцийн вектор B -тэй параллель болон параллель биш янз бүр байна. Соронзон орон дахь соронзон момент болон спины соронзон квант тоо M_s нь хоёулаа $2S + 1$ утгатай байна. Соронзон оронд M_s спины соронзон квант тоо бүхий хослоогүй электроны энергийн түвшин $2S \pm 1$ түвшнүүдэд салаалдаг. Хослоогүй электрон микродолгионоор өдөөгддөг ба энд микродолгионы энериги болон давтамж нь дараахи илэрхийлэлийн дагуу өгөгдсөн резонансын нөхцөл биелэх тохиодолд их энергитэй түвшин рүүгээ шилжине:

$$\hbar\nu = E_2 - E_1 = g\mu_B B_r, \quad (4)$$

энд \hbar нь Планкийн тогтмол, ν нь микродолгионы давтамж, g нь спектроскопик фактор, μ_B нь Борын магнитон, B_r нь резонансын соронзон орны индукцийн вектор, E_2 нь хослоогүй электронуудын үндсэн төлөвийн энериgi, E_1 нь хослоогүй электронуудын үндсэн төлөвийн энериgi. B индукцийн вектортэй соронзон орон дэх M_s соронзон спины квант тоо бүхий хослоогүй электроны энериgi дараахи хэлбэртэй байна.

$$E(M_s) = M_s g \mu_B B_r. \quad (5)$$

ЭПР эфектийг бас электроны спин резонанс (ЭСР) гэж нэрлэдэг. Учир нь парасоронзон материал дэх хослоогүй электронууд нь хослоогүй спинтэй байдаг. ЭПР (ЭСР) спектроскопийн үндэс нь дээр тодорхойлсон эфект болдог бөгөөд энэ нь парасоронзон дефектүүдийг судлах туршилтын аргын үндэс болдог. Парасоронзон материалуудыг соронзон оронд оруулахад тэгш 4 резонансын нөхцлийг хангах энериgi бүхий микродолгионыг шингээдэг. ЭПР спектроскопийг ашиглан шингээлт болон нэгдүгээр эрэмбийн уламжлалын шугамд анализ хийх болно. Нэгдүгээр эрэмбийн уламжлалын муруйн комплекс парасоронзон төвүүдийн систем бүхий дээжүүдийн хувьд маш чухал байдаг. Олон компонент бүхий ЭПР спектрын компонентүүдийн шугамын нарийвчлал шингээлтийн муруйн хувьд нэгдүгээр эрэмбийн уламжлалаар хялбар ялгагдана. Чөлөөт радикал бүхий парасоронзон материалын хувьд соронзон орны нөлөөгөөр $S = 1/2$ спин бүхий энериgi түвшинд Зееманы салалт болж хоёр түвшинтэй болно. Соронзон орон дэх чөлөөт радикалуудын Зееманы салалтыг зураг 3-т узүүлэв. Зураг 3-т соронзон оронтой болон оронгүй үе дахь чөлөөт радикалуудын хослоогүй электроны энериgi түвшин болон микродолгионы шингээлт болон нэгдүгээр эрэмбийн уламжлалын муруй зэргийг узүүлэв.



Зураг 3: $S = 1/2$ спинтэй чөлөөт радикалын соронзон орон дахь Зееманы эфект. Энд шингээлт болон эхний ЭПР шингээлтийн муруйг үзүүлэв. B -соронzon орны индукцийн вектор, B_r -соронзон резонансын индуциц, \hbar - Планкийн тогтмол, ν - микродолгионы давтамж, g - спектроскопик фактор, μ_B - Борын магнитон, $\hbar\nu = g\mu_B B_r$ -резонансын томъёо.

IV. ТУРШИЛТ

Судалгааны дээж болох цэвэр усан болор (SiO_2)-ийг тэнцүү хэсгүүдэд хуваагаад электроны цикл хурдаасгуур Микротрон МТ-22 (МУИС-ийн ЦФСТ, Цацрагийн урсгалын нягт $\Phi_\gamma \simeq (7.2 \cdot 10^{11} - 1.2 \cdot 10^{11}) \text{ Г/см}^2 \cdot \text{сек} \cdot \text{мкА}$, $I_e = 9 \text{ мкА}$) цацраг идэвхит үүсгүүр дээр $E_e = 22 \text{ МэВ}$ хүртлэх энериgi бүхий нил спектртэй саатлын гамма цацрагаар нэг цаг шарж бэлтгэнэ. Дээжны шараагүй хэсгийг шарсан дээжтэй харьцуулан судлахад ашиглах болно.


Дулааны боловсруулалт: Цацрагаар шарж бэлдсэн дээжний тодорхой хэсгүүдийг шатаах зууханд (МУИС-ийн орчны шинжилгээний лаборатори) 100°C болон 200°C температурт 24 цаг халааж дулааны боловсруулалтанд оруулан туршсан.

СЭПР2 (МУИС-ийн ЭПР спектроскопийн лаборатори) электроны парасоронзон резонансийн спектрометр ашиглан гамма

цацрагаар шарсан болон шараагүй, дулааны боловсруулалтанд оруулсан усанболовын дээжийн ЭПР спектрийг $\Delta H = 500$ Гс, $H_r = 1200$ Гс, $\tau = 0.3$ с, $\Delta t = 30$ с-ийн горимд хэмжсэн.


V. ҮР ДҮН

Сонгож авсан усанболов (SiO_2)-ын дээжээ γ - цацрагаар шарсны дараа дээж гүн хар өнгөтэй болж утаат болор болсон болон 200^0C температурт 24 цаг халааж дулааны боловсруулалтанд оруулсаны дараа буцаад тунгалагжиж байгааг зураг.4-т үзүүлэв. Гамма цацрагийн үйлчлэлээр



Зураг 4: Усанболов (SiO_2): a) байгалийн цэвэр дээж, b) γ цацрагаар шарсан дээж (Утаат болор), b) γ цацрагаар шарж утаат болор болгосон дээжийг 200^0C -т 24 цаг халаасны дараахи хагас тунгалаг усанболов.

усанболов дээжинд knock-on болон radiolysis процесс явагдсаны үр дунд маш олон тооны янз бүрийн дефектүүд үүсэж байгаагийн нэг нь парасоронзон төвүүд юм. Үүнийг бид ЭПР спектрскопи ашиглан хэмжсэнийг зураг.5-т үзүүлэв. Энд нунтаг дээжийг хэмжсэн учраас гадны соронзон оронтой харьцуулахад гажиг нь ямарваа нэг зонхилсон зүгшрэл үүсгэснээс болж илрэх резонансын хэсгүүд бүртгэгдэхгүй гэсэн уг юм. Нунтаг дээжинд үүссэн дефект нь бүх чиглэлд ижил магадлалтайгаар байрлах тул бүртгэгдэж буй спектр нь бүх дефектийн нийлбэр хувь нэмрийг үзүүлнэ. ЭПР спектрт өгч байгаа 1200 Гс орны үед үүсэж байгаа резонанс нь гамма цацрагаар шарсны дунд үүсэж байгаа парасоронзон дефектүүдэд харгалзана. Эндээс бид γ цацрагаар шарсан болон дулааны



Зураг 5: Цэвэр, γ цацрагаар шарсан болон 200^0C -т 24 цаг халаасан Усанболов (SiO_2) дээжийн ЭПР спектр.

боловсруулалтанд оруулсны дараа усанболов дээжинд үүсэж байгаа өнгөний хувиралыг тайлбарлах зорилгоор тухайн дээжинд үүсэж байгаа парасоронзон дефектийн концентрацийг нүүрсний эталон дээжний ЭПР спектртэй харьцуулах замаар үнэлсэн. γ цацрагаар шарсан усанболов дээжин дахь парасоронзон дефектийн концентарци $N_{ir} = 6.6 \cdot 10^{18}$ (спин/грамм) байгаа бол дулааны боловсруулалтанд оруулсны дараа $N_{ht} = 5.9 \cdot 10^{18}$ (спин/грамм) болж цөөрсөн байна. Эндээс γ цацрагийн үйлчлэлээр Усанболорт парасоронзон дефект үүсэх бөгөөд энэ дефект нь дулааны үйлчлэлээр эдгэж байгаа нь харагдаж байна.

VI. ДҮГНЭЛТ

Байгалийн хагас үнэт чулуу болох усанболов (SiO_2)-ийг γ цацрагаар үйлчлэхэд түүний өнгө өөрчлөгдөн утаат болор болж байна. γ цацраг бодистой харилцан үйлчилсэний дунд цацрагийн энергийс хамааран комптоны сарнил, фотопацхилгаан эфект, электрон позитроны хос үүсэх зэрэг процесс явагдсаны дунд кристаллд олон янзын дефект үүссэнэй улмаас түүний өнгө өөрчлөгддөг. Бид өмнө рентген дифракцийн аргаар усанболорт γ цацрагийн үйлчлэлээр атомын шилжилт хийж, кристалл гажиж байгааг тогтоосон[9]. Бид энэ ажлаар γ цацрагийн үйлчлэлээр усанболорт парасоронзон төвүүд үүсэж байгааг ЭПР спектроскопийн аргаар судлаж тогтоов. Судалгааны үр дунгээс үзэхэд гамма цацрагаар шарсны үр дунд олон тооны парасоронзон төвүүд үүсч байгаагаас гадна дулааны боловсруулалтын дунд эдгээр төвүүд өдгөөрч байгааг үзүүлэв. Цаашид ЭПР

спектроскопийн аргатай оптик шингээлтийн спектроскопийн аргыг хослуулан янз бүрийн горимд дулааны боловсруулалтанд оруулах замаар нарийвчлан судлах хэрэгтэй.

Талархал

Энэхүү ажлыг гүйцэтгэхэд дэмжлэг үзүүлж суурь судалгааны SST_018/2015 төслийг

- [1] Ed. Catlow R., "Defects and disorder in crystalline and amorphous solids" Kluwer Academic Publishers (1994)
- [2] Kittel C., "Introduction to Solid State Physics" John Wiley and Sons (1971).
- [3] Elliott S.R., "Physics of amorphous materials" Longman, London, 2 Ed. (1990).
- [4] Griscom D.L., J. Ceramic Society of Japan 99 (1991) 899
- [5] Eds. Devine R.A.B, Duraud J.P. and Dooryhée E., "Structure and imperfections in amorphous and crystalline silicon dioxide" John Wiley and Sons (2000).
- [6] Gupta R.P., Phys. Rev.B 32 (1985) 8278.
- [7] Chan S.L., Gladden L.F. and Elliott S.R., J. Non-Cryst. Sol. 106 (1988) 413.
- [8] Wertz JE, Bolton JR., "Electron Spin Resonance: Elementary Theory and Practical Applications" London: Chapman and Hall; 1986.
- [9] Ч.Цэцэнжаргал, Т.Очирхуяг, Н.Төвжаргал, Д.Баатархүү, Л.Ням-Очир. "Гамма цацрагийн үйлчилээр усан болор (SiO_2)-т үүсэх эфектийн судалгаа" МУИС-ийн эрдэм шинжилгээний бичиг 438, ФИЗИК сэтгүүл (20), 2015, 63
- [10] Л.Баяржаргал, Д.Сангаа, Д.Баатархүү, МУИС-ийн ЭШБ №179(10), 2003, 99-105
- [11] Б.Бумаа, А.Бадмаараг, Д.Баатархүү, Д.Сангаа., ШУА-ийн ФТХ-ийн ЭШБ №36, 2008.